



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

ИРГЭДИЙН ИНФЛЯЦЫН ХҮЛЭЭЛТИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА

2025 оны I улирал

2025 оны 4 дүгээр сар



I. ХУРААНГУЙ

“Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа”-ны мэдээллийг 2025 оны 4 дүгээр сарын 02-15-ны өдрүүдэд цуглуулж, Улаанбаатар хотын иргэдийн байршил, хүйс, насны бүлэг, өрхийн орлогын бүтцийг төлөөлөх 1,000 иргэнийг хамруулж, түүвэр судалгааны мэдээллийг боловсрууллаа. Судалгааны гол үр дүнг дараах байдлаар нэгтгэн танилцуулж байна.

- Судалгаанд Баянзүрх болон Сонгинохайрхан дүүрэгт оршин суудаг иргэд 42 хувийг бүрдүүлсэн бөгөөд 26-55 насны дээд боловсролтой иргэд түлхүү оролцлоо. Судалгаанд оролцогчдын хүйсийн харьцаа эмэгтэй, эрэгтэй харгалзан 55%, 45% байлаа.
- Түүвэр судалгаанд хамрагдсан иргэдийн хариултаас хүлээгдэж буй инфляцыг тооцвол:
 - 2025 оны II улирлын эцэст мэдрэмжид суурилсан инфляцын хүлээлтийн утга **9.2%**, чанарын хариултаас тооцсон инфляцын хүлээлтийн утга **12.0%**, тоон хариултаас тооцсон инфляцын хүлээлтийн утга **10.8%**-тай гарлаа.
 - 2026 оны I улирлын эцэст инфляц мэдрэмжид суурилсан аргаар **12.1%**, чанарын хариултаас тооцсон аргаар **12.5%**, тоон хариултын жигнэсэн дундаж утга **11.3%**-д хүрэх төлөвтэй байна.
- Өрхийн орлого болон зардлын ирэх улирлын хүлээлт хоёул нэмэгдэхээр байгаа ч зардлын өсөлт илүү хурдацтай байгаа тул өрхийн санхүүгийн тэнцэл муудах, хуримтлал буурах хандлага давамгайлж байна. Иргэдийн дийлэнх нь ирэх улиралд санхүүгийн байдлаа төлөвлөхөд хүндрэлтэй байна гэж үзжээ.
- Ажил эрхлэлтийн хүлээлт өмнөх улирлаас нэлээдгүй өссөн бөгөөд ирэх улиралд ажил эрхлэлт нэмэгдэх хүлээлт давамгайлж байгаа ч эдийн засаг удаашрах хүлээлт зонхилж, төгрөгийн ханш үргэлжлэн сулрах төлөвтэй байгааг иргэд илэрхийлжээ.
- Ирэх улиралд зээлийн хүү өсөх хүлээлт иргэдийн дунд илүү давамгайлж байна.

Зураг 1. Инфляцын хүлээлт




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

II. ИНФЛЯЦЫН ХҮЛЭЭЛТ


Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн чанарын хариултад үндэслэн өнгөрсөн хугацааны үнийн өсөлтийн мэдрэмжийн индексийг тооцоход өнгөрсөн 3 болон 12 сарын хугацааны хувьд ойролцоо утгатай гарч, өмнөх улирлын судалгааны үр дүнгээс бага зэрэг буурсан хэдий ч “инфляц өссөн” мужид хэвээр хадгалагдлаа (Зураг 2).

Ирэх хугацааны инфляцын хүлээлтийн индексийн хувьд ч мөн адил ирэх улирлын болон ирэх 1 жилийн хүлээлтийн индексийн утга өмнөх улирлаас бага зэргийн буурсан бөгөөд ирэх 1 жилийн хүлээлтийн индексийн утга өмнөх оны мөн үеийн утгаас бага зэргийн буураад байна. Гэсэн хэдий ч ирэх хугацааны инфляцын хүлээлтийн индексийн утга “инфляц өснө” мужид хадгалагдаж байна (Зураг 3).

Зураг 2. Инфляцын мэдрэмжийн индекс¹



Зураг 3. Инфляцын хүлээлтийн индекс



Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

Өнгөрсөн хугацааны инфляцын мэдрэмж (*perceived inflation*)² болон ирэх хугацааны хүлээлтийн талаар иргэдийн чанарын хариултад үндэслэн инфляцын утгыг тооцоход 2025 оны 6 сарын эцэст **9.2%**, 2026 оны эхний улирлын эцэст **12.1%**-д хүрэх хүлээлттэй байна (Зураг 4). Мөн чанарын хариултаас тооцсон³ инфляцын хүлээлтийн утга ирэх улиралд **12.0%**, ирэх 12 сард **12.5%**-тай гарлаа (Зураг 5). Харин инфляцын хүлээлтийн тоон утгаар асуусан хүлээгдэж буй утга ирэх улиралд **10.8%**, ирэх 12 сард буюу 2026 оны эхний улирлын эцэст **11.2%**-тай байх төлөвтэй байна (Зураг 6). Эдгээр 3 аргачлалын аль аль нь 2025 оны 6 дугаар сарын инфляц одоогийн түвшнээс бага зэрэг нэмэгдэх хүлээлттэйг харуулж байна. Ийнхүү 2023 оноос хойш

1 Бараа, үйлчилгээний үнийн ерөнхий түвшин өнгөрсөн хугацаатай харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөн талаар мэдрэмжийг асууж, “маш ихээр өссөн”, “нэлээдгүй өссөн”, “аажмаар өссөн”, “хэвэндээ” болон “буурсан” гэсэн хариултуудыг [3;-1] утгаар нормчилж чиглэлийн индексийг тооцсон болно.


2 Мэдрэгдсэн инфляцын утгыг [Forsells, Kenny](#) (2002) нарын боловсруулсан аргачлалд тулгуурлан тооцлоо.

3 Инфляцын хүлээлтийн чанарын хариултаас [Carlson, Parkin](#) (1975) нарын боловсруулсан аргачлалыг ашиглан хүлээлтийн утгыг тооцсон болно.


6 улирал дараалан буураад байсан инфляцын хүлээлтийн утга сүүлийн 3 улирал дараалан нэмэгдээд байна.

Иргэдийн тоон хариултаас харахад ирэх 3 болон 12 сарын инфляцын хүлээлтийн тархалт одоогийн түвшнээс нэмэгдэх чиглэлд буюу баруун тийш хэлбийлттэй байна (Зураг 7).


Зураг 4. Мэдрэмжид суурилсан инфляцын хүлээлт




Зураг 5. Чанарын хариултаас тооцсон инфляцын хүлээлт



Зураг 6. Тоон хариултаас тооцсон инфляцын хүлээлт



Зураг 7. Инфляцын хүлээлт, тоон хариултын тархалт




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа


III. ӨРХИЙН САНХҮҮГИЙН БАЙДАЛ

Өрхийн орлого 2025 оны II улиралд эерэг утгатай буюу бага зэргийн нэмэгдэх хүлээлттэй гарлаа (Зураг 8). Тухайлбал, өрхийн орлогын хүлээлт өмнөх улирлын утгаас 0.03 нэгжээр нэмэгдсэн нь эерэг үзүүлэлт болж байна. Өрхийн зардлын хүлээлт мөн тэлэх чиглэлд байгаа хэдий ч өмнөх улирлуудын утгаас нэлээдгүй буурч, өрхийн зардлын өсөлт саарах төлөвтэй байгааг илтгэж байна (Зураг 9). Гэсэн хэдий ч өрхийн зардлын өсөлт нь орлогын өсөлтөөс өндөр байхаар байна.

Зураг 8. Өрхийн орлогын хүлээлт, ирэх 3 сар



Зураг 9. Өрхийн зардлын хүлээлт, ирэх 3 сар



Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, ҮСХ

Өрхүүд хадгаламжаа бууруулах хүлээлт сүүлийн 4 улирал дараалан өндөр хэвээр гарлаа (Зураг 10). Өрхийн орлого бага зэргийн нэмэгдсэн ч хэрэглээ сүүлийн 5 улирал дараалан өндөр өсөлттэй байсан нь хуримтлал хийх боломжийг хязгаарлажээ. Гэсэн хэдий ч иргэдийн хугацаатай хадгаламж 2025 оны I улиралд 18.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 21 хувиар өсөөд байна. Нөгөө талаас, банкуудаас авсан иргэдийн хэрэглээний зээлийн үлдэгдэл 2025 оны эхний улирлын эцэст 12.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх онтой харьцуулахад 32 хувиар өсжээ. Ингэхдээ хэрэглээний чанаргүй зээлийн эзлэх хувь 3.0%-д хүрсэн нь 2022 оноос хойших хамгийн өндөр түвшин болж байна.


Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-оос эрхлэн гаргадаг “Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа”-ны 2024 оны IV улирлын нэрлэсэн дүнгээрх өрхийн дундаж орлого болон зардлын зөрүүгээр өрхийн санхүүгийн тэнцэл 79.6 мянган төгрөгийн алдагдалтай гарчээ. Өөрөөр хэлбэл, өрхүүд хэрэглээгээ хуримтлалаас илүүтэйгээр зээлээр санхүүжүүлж байна.

Ирэх улиралд санхүүгийн байдлаа төлөвлөхөд хүндрэлтэй байгаа талаар судалгаанд оролцогчдын дийлэнх нь дурджээ. Энэ нь эдийн засгийн тодорхой бус байдал өндөр хэвээр байгааг илтгэж байна (Зураг 11).


Иргэдийн банкнаас авсан хэрэглээний зээлийн үлдэгдэл, түүний жигнэсэн дундаж хүү болон хугацаагаар зээлийн сарын дундаж төлбөрийг тооцоход 2025 оны I улирлын эцсийн байдлаар 667.0 мянган төгрөг болж байна. Энэ нь өрхийн сарын дундаж нэрлэсэн орлогын 25 орчим

хувьтай тэнцэх бөгөөд энэхүү үзүүлэлт сүүлийн 1 жилийн хугацаанд тасралтгүй нэмэгдсээр байна.

Зураг 10. Өрхийн хадгаламжийн хүлээлт, ирэх 3 сар



Зураг 11. Санхүүгийн байдлын төлөвлөлт, ирэх 3 сар




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, Монголбанк, ҮСХ


IV. ИРГЭДИЙН МАКРО ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХҮЛЭЭЛТ

Ажил эрхлэлтийн үзүүлэлт өмнөх улирлын утгаас нэлээдгүй нэмэгдэж, ирэх улиралд ажил эрхлэлт нэмэгдэх хүлээлт давамгайллаа (Зураг 12). Гэсэн хэдий ч ҮСХ-оос мэдээлж буйгаар ажиллагчдын тооны өсөлт сүүлийн 4 улирал дараалан буурсан байна. Мөн эдийн засгийн өсөлтийн хүлээлтийн үзүүлэлтийг тооцоход -0.15 утгатай буюу эдийн засаг агших хүлээлттэй гарлаа (Зураг 13). Гэсэн хэдий ч энэ нь өмнөх улирлын утгатай харьцуулахад бага зэргийн сайжирсан үзүүлэлт болж байна.

Зураг 12. Ажил эрхлэлтийн хүлээлт, ирэх 3 сар



Зураг 13. Эдийн засгийн байдлын талаарх хүлээлт, ирэх 3 сар




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, ҮСХ


2025 оны I улиралд 1 ам.доллар дунджаар 3,455 төгрөгтэй тэнцэж, өмнөх оны мөн үеэс 2 хувиар суларчээ. Төгрөгийн ханш ирэх улиралд үргэлжлэн суларна гэж иргэдийн дийлэнх үзэж байна (Зураг 14).

Зээлийн хүүний хувьд ирэх улиралд хүү өсөх хүлээлт иргэдийн дунд давамгайлж, өмнөх улирлын утгаас нэлээдгүй нэмэгдээд байна (Зураг 15). Иргэдэд олгосон банкны хэрэглээний зээлийн жигнэсэн дундаж хүү сүүлийн 2 жилд төдийлөн өөрчлөлт ороогүй буюу 2025 оны I улиралд 17.1%-тай байна.

Зураг 14. Гадаад валютын ханишийн хүлээлт, ирэх 3 сар



Зураг 15. Зээлийн хүүний талаарх хүлээлт, ирэх 3 сар




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, Монголбанк


V. ХАВСРАЛТ

“Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа”-ний мэдээллийг 2025 оны 4 дүгээр сарын 02-15-ны өдрүүдэд Улаанбаатар хотод оршин суугаа насанд хүрсэн иргэдээс утсаар ярилцлага хийх байдлаар цуглуулсан бөгөөд нийт 1,001 иргэн судалгаанд оролцлоо. Үүнээс давхардсан мэдээллийг хасч тооцоход судалгаанд оролцсон 1,000 иргэд нь эх олонлогоо бүрэн төлөөлөх чадвартай байна. Тухайлбал, судалгаанд оролцогчдын оршин суугаа хаягийг ҮСХ-оос зарласан 2023 онд Улаанбаатарт оршин суугаа хүн ам (насанд хүрсэн иргэд)-ын бүтэцтэй харьцуулахад харгалзан пропорциональ байна (Зураг 16). Баянзүрх болон Сонгинохайрхан дүүргийн иргэд судалгаанд оролцогчдын 42 хувийг бүрдүүлсэн бол энэ удаагийн судалгаанд оролцогчдын 55% нь эмэгтэй, 45% нь эрэгтэй байна (Зураг 17).

Зураг 16. Судалгаанд оролцогчдын оршин суугаа хаяг




Зураг 17. Судалгаанд оролцогчдын хүйс




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, ҮСХ

Мөн судалгаанд оролцогчдыг насны ангиллаар харвал 36-55 насны иргэд 54 хувийг бүрдүүлсэн бөгөөд боловсролын хувьд дээд болон бүрэн дунд боловсролтой иргэд түлхүү оролцлоо (Зураг 18-Зураг 19).

Зураг 18. Судалгаанд оролцогчдын насны ангилал




Зураг 19. Судалгаанд оролцогчдын боловсролын байдал




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, ҮСХ

Ажил эрхлэлтийн хувьд энэ удаагийн судалгаанд хувийн байгууллагад ажилладаг болон тэтгэврийн иргэд голлон хамрагдлаа (Зураг 20). Судалгаанд оролцогч иргэдийн өрхийн орлогын бүлэглэлт нь ҮСХ-оос зохион байгуулдаг “Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа”-ны өрхүүдийг мөнгөн орлогоор бүлэглэсэн хамгийн сүүлийн буюу 2024 оны IV улирлын үр дүнтэй харгалзан нийцтэй байна (Зураг 21).

Зураг 20. Судалгаанд оролцогчдын ажил эрхлэлт



Зураг 21. Судалгаанд оролцогчдын орлогын бүлэглэлт



Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, ҮСХ